



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2023/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Чойбалсан хот 2023 он	Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 204

танай _____ -ны № _____ -т

Г БАЯН-УУЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.БАТХУЯГ ТАНАА

Г Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яам 2022 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Улсын төсвийн хуваарь болон санхүүжилт БШУЯ, БЕГ-аас шууд хуваарилагдан хянагдаж ирдэг болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилгоор энэ хичээлийн жилээс Боловсролын нэгдсэн мэдээллийн систем /esis/-ийн бүх үйл ажиллагаа тухайлбал: багш ажилтан, ажилчдын өөрчлөгдсөн цалин, бусад нэмэгдлүүд,

011020177

холбоо барих мэдээлэл, байршил, үндэсний болон орон нутгийн сургалтад хамрагдсан байдал, сурагчдын үнэлгээ, харьяалал, байршил, асран хамгаалагчийн мэдээлэл, багш нарын цахим журналын шинэчлэл, санхүү, хөрөнгийн мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг үйлдлүүд шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан зохих журам тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь мэдээллийг оруулснаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь БШУЯ болон бусад яамдуудын мэдээллийн эх үүсвэр болон ашиглагдаж байгаагаараа онцлог байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	136,668,666.11	187,180,517.74
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	48,893,974.63
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	48,893,974.63
3121	Төгрөг	0.00	48,893,974.63
31211	Төрийн сангийн харилцах	0.00	48,893,974.63
35	БАРАА МАТЕРИАЛ	136,668,666.11	138,286,543.11
354	Хангамжийн материал	136,668,666.11	138,286,543.11
35410	Бичиг хэргийн материал	29,340,773.03	34,251,450.03
35420	Аж ахуйн материал	96,589,393.08	99,615,093.08
35440	Түлш, шатах тослох материал	10,738,500.00	4,420,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,360,369,673.16	4,319,686,812.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,360,369,673.16	4,319,686,812.07
392	Биет хөрөнгө	4,278,644,673.36	4,238,038,812.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,883,579,250.07	4,849,887,156.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-909,262,556.12	-960,147,495.38
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	191,223,107.30	266,461,415.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-127,693,628.41	-149,716,470.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	108,922,083.07	123,952,199.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	-56,325,977.07	-72,330,107.27
39214	Бусад үндсэн хөрөнгө	244,527,758.00	244,527,758.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-56,325,363.48	-64,595,643.26
393	Биет бус хөрөнгө	81,724,999.80	81,647,999.76
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-385,000.20	-462,000.24
39303	Бусад биет бус хөрөнгө	81,340,000.00	81,340,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,497,038,339.27	4,506,867,329.81
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,497,038,339.27	4,506,867,329.81
51	Засгийн газрын хувь оролцоо	4,497,038,339.27	4,506,867,329.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	518,879,854.43	518,879,854.43
51101	Өмч: - төрийн	518,879,854.43	518,879,854.43
512	Хуримтлагдсан үр дүн	3,538,551,473.90	3,608,442,385.58
51210	Өмнөх үеийн үр дүн	3,692,247,428.16	-898,424,944.23
51220	Тайлант үеийн үр дүн	-153,695,954.26	4,506,867,329.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	439,607,010.94	379,545,089.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,497,038,339.27	4,506,867,329.81

**Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,460,914,136.00	6,522,111,588.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,997,880.00	4,538,128,366.27
120	Нийтлэг татварын бус орлого	15,997,880.00	4,538,128,366.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,997,880.00	4,410,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,997,880.00	3,550,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		860,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		4,383,665,897.16
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		150,052,269.11
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,444,916,256.00	1,983,983,222.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,381,382,100.00	1,768,580,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,768,580,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,291,687,700.00	-
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	89,694,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,534,156.00	14,953,322.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,718,156.00	14,953,322.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	200,449,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	200,449,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,614,550,730.46	2,015,244,258.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,614,550,730.46	2,015,244,258.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,505,285,268.46	1,886,021,243.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,063,800,408.00	1,310,175,255.82
210101	Үндсэн цалин	786,772,708.00	972,290,937.82
210102	Нэмэгдэл	196,982,000.00	286,035,618.00
210104	Урамшуулал	80,045,700.00	51,848,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,331,700.00	166,067,593.33
210201	Тэтгэврийн даатгал	97,423,900.00	113,699,900.59
210202	Тэтгэмжийн даатгал	10,528,800.00	13,525,198.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,622,900.00	10,039,453.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,093,300.00	2,744,923.35
210205	Эрүүл мэндийн даатгал	20,662,800.00	26,058,117.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,609,549.00	88,304,013.00
210301	Гэрэл, цахилгаан	10,198,849.00	16,643,813.00
210302	Түлш, халаалт	43,410,700.00	69,180,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,479,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,039,149.42	-
210401	Бичиг хэрэг	1,706,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,037,100.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,235,316.00	-
210404	Ном, хэвлэл	1,776,000.00	-

**Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,214,406.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,294,400.00	-
210408	Бараа материал акталсны зардал	53,775,427.42	-
2105	Нормативт зардал	32,159,315.00	60,844,770.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	870,000.00	-
210502	Хоол, хүнс	30,609,315.00	60,844,770.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	680,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,259,100.00	8,933,500.00
210604	Урсгал засвар	4,259,100.00	8,933,500.00
2107	Томилолт, зочны зардал	168,000.00	-
210702	Дотоод албан томилолт	168,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800,000.00	59,256,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	440,000.00	46,612,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	12,644,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	141,118,047.04	192,439,311.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,904,000.00	41,976,226.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,079,000.00	17,426,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	134,135,047.04	133,036,185.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	109,265,462.00	129,223,015.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,898,134.00	129,168,337.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,750,700.00	114,715,015.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,017,724.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	40,129,710.00	14,453,322.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,367,328.00	54,678.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,367,328.00	54,678.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(153,636,594.46)	4,506,867,329.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(153,636,594.46)	4,506,867,329.81

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,444,916,256.00	1,988,393,422.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,410,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,410,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,410,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,550,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	860,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,444,916,256.00	1,983,983,222.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,291,687,700.00	1,768,580,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,768,580,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,534,156.00	14,953,322.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,718,156.00	14,953,322.00

**Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	89,694,400.00	200,449,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,694,400.00	200,449,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,444,916,256.00</u>	<u>1,870,442,347.37</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,444,916,256.00</u>	<u>1,870,442,347.37</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,335,650,794.00</u>	<u>1,741,219,332.15</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,063,800,408.00	1,310,175,255.82
210101	Үндсэн цалин	786,772,708.00	972,290,937.82
210102	Нэмэгдэл	196,982,000.00	286,035,618.00
210104	Урамшуулал	80,045,700.00	51,848,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,331,700.00	166,067,593.33
210201	Тэтгэврийн даатгал	97,423,900.00	113,699,900.59
210202	Тэтгэмжийн даатгал	10,528,800.00	13,525,198.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,622,900.00	10,039,453.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,093,300.00	2,744,923.35
210205	Эрүүл мэндийн даатгал	20,662,800.00	26,058,117.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,348,049.00	81,985,513.00
210301	Гэрэл, цахилгаан	10,198,849.00	16,643,813.00
210302	Түлш, халаалт	54,149,200.00	62,862,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,479,700.00
2105	Нормативт зардал	32,339,315.00	60,844,770.00
210502	Хоол, хүнс	30,609,315.00	60,844,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,735,000.00	9,093,500.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	9,093,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800,000.00	59,256,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	440,000.00	46,612,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	12,644,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,886,000.00	53,795,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,904,000.00	35,962,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,982,000.00	17,833,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>109,265,462.00</u>	<u>129,223,015.22</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,898,134.00	129,168,337.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,750,700.00	114,715,015.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	40,129,710.00	14,453,322.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,367,328.00	54,678.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,367,328.00	54,678.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	<u>117,951,074.63</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	<u>69,057,100.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	<u>69,057,100.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	69,057,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	69,057,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>(69,057,100.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	48,893,974.63

**Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	48,893,974.63
----	--	---	---------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	518,879,854.43	439,663,010.94	3,692,191,428.16	0.00	4,650,734,293.53
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	56,000.00	0.00	56,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	518,879,854.43	439,663,010.94	3,692,247,428.16	0.00	4,650,790,293.53
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-56,000.00	0.00	0.00	-56,000.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-153,695,954.26	0.00	-153,695,954.26
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	518,879,854.43	439,607,010.94	3,538,551,473.90	0.00	4,497,038,339.27
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	518,879,854.43	439,607,010.94	3,538,551,473.90	0.00	4,497,038,339.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-4,436,976,418.13	0.00	-4,436,976,418.13
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	518,879,854.43	439,607,010.94	-898,424,944.23	0.00	60,061,921.14
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-60,061,921.14	0.00	0.00	-60,061,921.14
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	4,506,867,329.81	0.00	4,506,867,329.81
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	518,879,854.43	379,545,089.80	3,608,442,385.58	0.00	4,506,867,329.81

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,973,700,100.00	1,924,491,447.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,973,700,100.00	1,924,491,447.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,855,813,421.78	1,809,776,432.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,344,981,184.96	1,310,175,255.82
210101	Үндсэн цалин	1,003,473,334.96	972,290,937.82
210102	Нэмэгдэл	289,309,150.00	286,035,618.00
210104	Урамшуулал	52,198,700.00	51,848,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,388,323.82	166,067,593.33
210201	Тэтгэврийн даатгал	114,600,384.33	113,699,900.59
210202	Тэтгэмжийн даатгал	13,482,386.45	13,525,198.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,637,257.96	10,039,453.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,823,091.28	2,744,923.35
210205	Эрүүл мэндийн даатгал	26,845,203.80	26,058,117.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,985,513.00	81,985,513.00
210301	Гэрэл, цахилгаан	16,643,813.00	16,643,813.00
210302	Түлш, халаалт	62,862,000.00	62,862,000.00

**Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210303	Цэвэр, бохир ус	2,479,700.00	2,479,700.00
2105	Нормативт зардал	69,492,900.00	60,844,770.00
210502	Хоол, хүнс	69,492,900.00	60,844,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,583,500.00	9,583,500.00
210604	Урсгал засвар	9,638,178.22	9,583,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,256,800.00	59,256,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,612,800.00	46,612,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,644,000.00	12,644,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,125,200.00	121,863,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,159,200.00	102,897,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,966,000.00	18,966,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,832,000.00	114,715,015.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,832,000.00	114,715,015.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	117,832,000.00	114,715,015.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,973,700,100.00	1,973,385,421.78
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,768,580,200.00	1,768,580,200.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,768,580,200.00	1,768,580,200.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,670,200.00	4,410,200.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,550,200.00	3,550,200.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,120,000.00	860,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	200,449,700.00	200,395,021.78
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	200,449,700.00	200,395,021.78
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	48,893,974.63

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,953,322.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,953,322.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,453,322.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,453,322.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,453,322.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,953,322.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,953,322.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,953,322.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 57,494.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 57,494.1 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.1-д "албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ" гэсэн заалтуудыг зөрчиж нэр данс зөрүүтэй гүйлгээ болон хөдөлмөрийн чадвар түр алдалтын 57,494.1 төгрөгийг гүйлгээнд бүртгэл хөтлөөгүй байна.

Аудитаар нийт 5,240.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2 албан шаардлага хүргүүлж, 5,240.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 17 дугаар зүйлийн 17.1. "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 30.4. "Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана", 30.4.1 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах", 30.4.2 "энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах", 30.4.3 "энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах", 34 дүгээр зүйлийн 34.3 "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалтууд, Санхүүгийн тайлангийн "үнэлгээ", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нийт зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

5,240.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн, цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас шаардаж бүрдүүлээгүй байна. Энэ нь УСНББОУС-1 санхүүгийн тайлангийн толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.1-д "албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ" гэсэн заалтуудыг зөрчиж "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх

Дээрх албан шаарлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нэр данс зөрүүтэй гүйлгээ болон хөдөлмөрийн чадвар түр алдалтын 57,494.1 төгрөгийг гүйлгээнд бүртгэл хөтлөөгүй	1	57,494.1	1	57,494.1			1	57,494.1			1	57,494.1
Дүн	1	57,494.1	1	57,494.1			1	57,494.1			1	57,494.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан./мод нүүрс гэх мэт/	1	-			1	-		
Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	-			1	-		
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн, цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас шаардаж бүрдүүлээгүй байна.	1	5,240.0					1	5,240.0
Нийт дүн	3	5,240.0			2	-	1	5,240.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд гэрэл цахилгаан, дулааны зардалд Тайлант хугацаанд 81985.5 мянган төгрөг зарцуулсан ба өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 23.5%-иар өссөн байна.	1						-	1
Нийт дүн	1	-					-	1



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 91/01 ДОО-2023/150/НА-СТА-ТШЗ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2 "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эд хөрөнгийн тооллого хийгдсэний дараа хөрөнгийн тооцоог бодож, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулсан байх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Батхуяг, нягтлан бодогч Б.Дуламжав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ийн
ЗАХИРАЛ

И.СЭМЖИДМАА

Д.АРИУНАА

011040343



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 92/02 200-2023/150/НА-СТА-ТШЗ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 17 дугаар зүйлийн 17.1. "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 30.4. "Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана", 30.4.1 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах", 30.4.2 "энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах", 30.4.3 "энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах", 34 дүгээр зүйлийн 34.3 "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


011040346

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, алдаа зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Батхуяг, нягтлан бодогч Б.Дуламжав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



И.СЭМЖИДМАА

Д.АРИУНАА